

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

Монгол анагаах ухаанд хэрэглэгдэх эрдсийн гаралтай эмийн тоо, таних аргыг харьцуулсан судалгаа

Золзаяа Б.¹, Ганбаатар А.¹, Өөдлөхцэцэг Б.², Өлзий О.²

¹ӨМӨЗО-ны Үндэстний их сургуулийн докторант

²Монгол эм, эмнэлгийн дээд сургууль

e-mail: Zoloo8402@yahoo.com

Abstract

Comparative study on identification method and number of mineral based drugs in Mongolian traditional medicine

Zolzaya B.¹, Ganbaatar A.¹, Uudlukhtsetseg B.², Ulzii O.²

¹Doctoral degree candidate student of Inner Mongolia National University

²Mongolian Drugs and Medicine College

E-mail: Zoloo8402@yahoo.com

Introduction

It is necessary and right to study and analyze all aspects of drug materials now when number of mineral based drugs are reducing. Especially it is very important for further researches to properly establish names and number of raw materials for traditional drugs based on ancient scripts.

Goal

To carry out comparative study on mineral based drugs numbers and their differences mentioned in Mongolian and Tibetan manuscripts about drug identification methods using 'Four basics of medicine' book and its interpretations as a source.

Materials and Methods

The study was conducted using methods of 'Comparing manuscript sources studies', 'Analyses and syntheses' for determining numbers and described with 'Hermeneutics' methodology. The study was based on approved methodology and ethical review in December 2018.

Results

As it was compiled from manuscripts number of drugs mentioned in Four basic roots of medicine was 57, Ancestors' important teachings – 68, Blue binderya – 77, Golden descript – 87, Clear crystal beads about medicine – 134, White crystal mirror – 121, Beauty eyes dīcor – 96. It is seen that books written about mineral based drugs became more comprehensive compared with previous manuscripts and authors were trying to reflect their on drug identification methods and ideas.

Conclusion:

1. The same time it evidences that traditional medicine was enriched year by year with innovation and searches of every generation scientists.
2. In "The four basics of medicine" manuscript theoretical book they described 57 mineral based traditional drugs but in other studies that number increased to 121 which means in manuscripts like "Basics of magic" and "Basics of future" drugs used that time were described more comprehensive.

Key words: Comparative, mineral, number, source manuscript

Pp. 50-53, Table 1, References 25

Оршил:

Эрдэс хэмээх ухагдахуун нь саяхан болтол дэлхийн чулуулаг бүрхүүлд геологийн процессийн үр дүнд бий болсон химийн нэгдлүүд хэмээн үздэг байв. Гэвч сансар судлал, дэлхийн гүний судалгаанд эрдсийн тухай дээрх ойлголтийг өөрчлөхөд хүргэж байна. Одоо үед физик химийн нэг болон хэд хэдэн элементүүдээс тогтсон байгальд үүссэн бодисыг эрдэс гэж үздэг болов. Иймд эрдэс нь байгалийн бүтээгдэхүүн учир дэлхийн гүнд, өнгөн хөрсөнд, сансарын орчинд хаа ч үүссэн байж болно [1]. 1636 онд Италийн эрдэмтэн Бернард Цезий анх удаа “минерал” гэдэг үгийг хэргэлснээр эрдэс судлалын ухааны судлах объект гарч ирсэн байдаг [2]. Гэтэл үүнээс эрт уламжлалт анагаах ухаанд эмийн зүйлдээ эрдсийн гаралтай төрөл бүрийн жонш, төмөр, цахиур агуулсан эрдсүүд, шавар, давс зэргийг хэрэглэж байсан түүхтэй (Ж.Оюун, 2006). Эрдсийн гаралтай эм нь Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэх эмийн түүхий эдийн төрөл зүйлээс эрдэнийн эм, чулуун эм, шороон эм, давсны гаралтай эмүүдэд их дурдагдсан [3] байх агаад эдгээрийн нэр тоо болон таних аргын талаар Ишбалжирын “Эмийн нэр ба эмт бодисыг таних болор толь”, “Лхантив чандил”, Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг”, Лувсанчүлтэмийн “Эрдэс шороон эмийн судар”, Данзанпунцагийн “Эмийн хир үгүй болор эрхи” гэх мэт нэлээд бүтээлүүдэд тухайн цаг үеийн эрдэмтэн мэргэдүүд өөр өөрийн үзэлтийг шингээж эмийн нэр, тоо хэмжээ, таних арга, ангиллын хувьд харилцан адилгүй туурвижээ. Тиймээс байгалийн эх баялаг ховордож байгаа одоо үед эмийн материалд бүх талын судалгаа шинжлэл хийх нь зөв бөгөөд энэ тэргүүнд сурвалж бичиг дэх ирэлтээр дамжуулан эмийн түүхий эдийн нэрс хийгээд тоо хэмжээг үнэн зөв тодруулах нь цааш цаашдын судалгаанд чухал билээ.

Материал, арга зүй

Судалгааг 2018 оны 12 сард баталсан судалгааны сэдэв, аргачлал, ёс зүйн хурлын шийдвэрийг үндэслэн судалгааны гол хэрэглэгдэхүүн болгож тухайн үеийн гол гарын авлага [4] болсон “Анагаах ухааны дөрвөн үндэс” VII зуун (Дэлгэрүүлсэн он X зуун) [5], “Дээдсийн чухал сургааль” Лодойжалба 1542-1545 он [6, 7], “Хөх биндэръяа” Дэсридсанжаажамц 1653-1705 он [8, 9], “Алтан хадмал” Лувсанчойриг 1650-аас дээш он [10, 11], “Эмийн хир үгүй болор эрхи” Данзанпунцаг 1727 он [12, 13], “Цагаан болор толь” Ишбалжир 1750-аас дээш он [14, 15], “Үзэсгэлэнт нүдэн чимэг” Жамбалдорж 1800 -аас дээш онд [16, 17] зохиогдсон бүтээлүүдийг “Эх бичиг сурвалж судлалыг төрөлжүүлэх арга”-ыг ашиглан он

цагын дараалал болон Монгол, Төвд бүтээлээр ангилж, “Эх бичиг сурвалж судлалыг харьцуулах арга”, “Анализ синтезийн арга”-аар тоо хэмжээг тодруулж, “Герменевтикийн”-ийн аргаар тайлбар хийсэн болно.

Үр дүн:

Судалгаанд хамрагдсан зохиолуудын агуулга, эрдсийн гаралтай эмийн онцлог тус бүрээр авч үзэхэд:

1. Эх сурвалж бичиг болох АУДҮ-ийн “Номлохуйн үндэс” Найруулах эмийн орны Эмийн чадлыг үзүүлсэн 20-р бүлэгт эмийн аймгийг наймд хувааснаас эрдэнэ эмийн аймагт-10, чулуун эмийн аймагт-38, шороон эмийн аймагт-11 нийт 59 зүйл эмийн чадлыг дурьджээ. Үүнээс эрдсийн гаралтай эм 54 байж жуган, хув, лууны яс нэмэгдэж нийт 57 эрдсийн гаралтай эмийн тус тусын чадлыг өгүүлсэн байна.
2. Эх сурвалж бичгийн гол тайлбар зохиолуудыг тодруулвал:

“Дээдсийн чухал сургааль”-д АУДҮ-д дурьдсан нэрсээс гадна эмт бодисын чадал болон гарах газар, онцлог шинжийг дурьдсан байх агаад ялангуяа тухайн эмийн уг гарал үүсэл (язгуур)-ийг нь голлон барьжээ. Мөн АУДҮ-т дурьдаагүй 11 эрдсийн гаралтай эмийн нэрийг дашрамд нь дурьджээ.

“Хөх биндэръяа” нь “Дээдсийн чухал сургааль” дээр дэлгэрүүлж эмт бодис тус тусын 1-2 гол нэр болон бусад өөр нэрийн тоо хэмжээг өгүүлснээрээ онцлог бөгөөд АУДҮ-т дурьдаагүй 20-иод эмийн нэрийг дашрамд нь дурьджээ.
3. Эм таних аргын талаар туурвисан Төвд эрдэмтдийн зохиолуудыг тодруулвал:

“Алтан хадмал”-д эмийн аймаг бүлгийг нилээд нарийвчлан тэмдэглэсэн байх бөгөөд эрдэнийн эмийг үл хөдлөх махбодитой, хөдлөх махбодитой хэмээн ерөнхий хоёр ангилж үл хөдлөх махбодийг дээд эрдэнэ, доод эрдэнэ гээд дээд эрдэнэд амгаланд ажирсаны шарилын зүйлс 4, доод эрдэнийг шил чулууны зүйл, хөдөлдөг махбодиос гарсан хайлагдах чанартай эрдэнэ гэжээ. Чулуун эмийг нарийн бүдүүн гэж хоёр ерөнхий ангилаад бүдүүнийг нь эрдэнийн чулуу, чандманын чулуу, эгэлийн чулуу гэж хуваан үүнээс эгэлийн чулууг нь дурьдсан байна.

“Эмийн хир үгүй болор эрхи”-нь ангиллын хувьд эрдэнийн эмийг хайлагдах, үл хайлагдах махбодитой, чулуу, шороон эмийг өөрөө гарсан хиймэл гэж ангилаад “Алтан хадмал”-аас

илүүтэйгээр товч бөгөөд таних аргын талаар тодорхой бичсэн байна. Ялангуяа гарах газар болон тухайн үеийн үнэ ханшийг нь голчлон дурьджээ.

4. Эм таних аргын талаар туурвисан Монгол эрдэмтдийн зохиолуудыг тодруулвал:

“Цагаан болор толь” нь ангиллын хувьд “Эмийн хир үгүй болор эрхи”-тэй адил байхаар, чадал хийгээд таних аргын талаар товч болон тодорхой, эрдэнийн эмийн таних аргыг цөөн дурьдаад эмийн нэрийн ялгамжтай талыг тодруулан Санскрит, Манж, Монгол, Түвд хэлээр тохируулан туурвижээ.

“Үзэсгэлэнт нүдэн чимэг” нь агиллын хувьд давсан эмийн аймгийг нэмж өөрөө бүтсэн, хиймэл хэмээн ангилаад эмийн нэрийн эндүүрлээс сэргийлж Манж-Хятад нэрийг төвд нэртэй тааруулан Төвдөөр галиглан бичсэн байх бөгөөд эм таних аргыг зурагт тайлбар болгон дүрсжүүлснээрээ эм таних аргыг илүү ойр болгож бусдад гарын авлага болсон онцлогтой байна.

5. Судалгаанд хамрагдсан зохиолууд дахь эрдсийн гаралтай эмийн тоо хэмжээг хүснэгтээр тодруулбал:

Table 1. Comparing mineral based drugs numbers and their differences written Mongolian and Tibetan medicine

№	Script Treasure		Minerals				Total
			Stone	Dirt	Other		
1	'The four basic roots of medicine'		6	35	10	6	57
2	'Ancestors' important teachings'		6	44	11	7	68
3	'Blue binderya'		7	45	12	13	77
4	'Golden descript'		33	34	10	0	87
5	'Clear crystal beads about medicine'		50	55	12	17	134
6	'White crystal mirror'	name	57	45	21	11	134
		method	11	40	11	9	71
7	'Beauty eyes dйcor'		30	42	5	18	95

Хэлцэмж:

Т.Ганбаатар (1993 он)-ын “Монголын уламжлалт эмнэлэгт хэрэглэгдэж байсан зарим эрдсүүд”-д өгүүлсэнчлэн эмчилгээ, засал, эм, тан болгож хэрэглэж байсан байгалийн эрдсийг өдгөө сэргээн олборлож, найрлага, химийн бүрэлдэхүүнд шинжлэх ухаанч үндэслэлтэй тайлбарлаж, бүрэн ашиглах нь өнөөгийн цаг үеийн чухал зорилт болж байна. Эрдсийн гаралтай эмийн түүхий эдийн анагаах ухааны хэрэглээ, эмийн үйлдлийн талаар Ц.Хайдав, О.Шерхан [18], Т.Ганбаатар [19], эмийн ёгт нэрийн тайлбарын талаар Л.Анхцацрал [20] нарын судлаачдын судалгааг эс тооцвол эмийн тоо хэмжээг тодотгон харьцуулсан судалгаа ховор байна.

Эх сурвалжуудыг он цагийн дарааллаар авч үзвэл эмийн тоо, таних арга, агуулгын хувьд урьд урьдын зохиолуудаас дэлгэрэнгүй болж зохиогчид өөр өөрийн эм таних арга барил, үзэл санааг шингээж өгсөн байгаа нь анагаах ухаан жилээс жилд дээдэс мэргэдийн оюун ухаан, ахуй үесийн шинэчлэлээр хөгжиж, дэлгэрч байсан гэдгийг Ш.Болд(2006он) [21],

Н.Дашзэвэг (1988 он) [22], Б.Жигмэд (2004 он) [23] нарын судлаачдын нэгэн адил харуулж байна.

Эрдсийн эмийн тоо харилцан адилгүй байгаа нь зохиогчид өөр өөрийн үзэлтээр эмийн нэр давхцах, эндүүрлээс сэргийлэх, таних арга, олдоц зэргээс шалтгаалсан гэж үзэхээр байна. Мөн уг гарал нь нэг эмийн зүйл боловч хоёр өөр өнгө, нэршилтэй байхыг хоёр тусад нь ангилж бичсэн (Гарбочигтүб-Дүнзэ, Дөрвөлжчулуу-Паванлонву, Жоглама-Хятад цал, Танихир-Тодлэгор г.м) [8,9], тухайн үедээ уг сурвалж нь устах төдий байсан одоогоор дуун төдий болсон (Мажадинда, Зэндмэнэ, Чунин, Идшиннорву, Таиго, Долад, Дочу г.м) [10,11,12] эмийн тохиолдол нилээдгүй байна.

Ангиллын талаар авч үзэхэд эрдэнийн эм, чулуун эм зэрэг нь одоох эрдсийн талаархи ангилалтай тохирохгүй байгаа нь харагдаж байна [1, 2, 24]. Тиймээс орчин үеийн шинжлэх ухааны ололт дэвшилтэд тулгуурлан гарч буй эмийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн эрдсийн гаралтай эмийн тоо хэмжээ, ангиллыг шинэчлэх нь зүйтэй болов уу.

Эрдсийн эмийг таних талаар Жамбалдоржийн зохиосон “Үзэсгэлэнт нүдэн чимэг” нь эмийн тухай зурагт тайлбар хавсаргасан цор ганц зохиол гэдгээрээ Х.Чагданхорлоо (2014 он) [3], Д.Алтанчулуу (2015 он) [25] нарын судалгаатай нийцэж байгаа бөгөөд эндүүрэлгүйгээр таних арга, түүнийг эмэнд номхотгон хэрэглэх талаас нь нэмэрлэн бичсэнээрээ бусад харьцуулсан зохиолуудаас давуу талтай байна.

Дүгнэлт:

1. Эрдсийн гаралтай эмийн нэр тоо хэмжээг тус тусад нь нэгтгэн дүгнэвэл АУДҮ-т 57, “Дээдсийн чухал сургааль”-д 68, “Хөх биндэрьяа”-д 77, “Алтан хадмал”-д 87, “Эмийн хир үгүй болор эрхи”-д 134, “Цагаан болор толь”-д 134, “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т 95 байна.
2. АУДҮ-ийн онолын үдэст 57 зүйлийн эрдсийн гаралтай эмийн чадлыг тус тусад нь өгүүлсэн хэдий ч бусад зохиолд 64-77 зүйл тоогоор нэмэгдсэн байгаа нь тухайн үед хэрэглэгдэж байсан эмийн зүйлийг нэмсэн нөгөөтэйгүүр АУДҮ-ийн “Увидасын үндэс” болон “Хойтын үндэс”-т нэр өгүүлсэн байж болох юм.

Ном зүй

1. Дашням Б. “Эрдэс судлал”, Дархан, 2001, х.5-180
2. Гүндсамбуу Ц. “Эрдэс судлалын үндэс”, УБ, 1970, х.3-5
3. Чагданхорлоо Х. “Эрдэнийн эмийг таних ухаанд Монголчуудын оруулсан хувь нэмрийг судлах асуудалд” магистрын зэрэг горилсон бүтээл, УБ, 2013, х.25-34
4. Ганбаяр Я. “Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс” зохиолын судалгаа, Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, УБ, 2008, х.94-101
5. Ютиг Ёндонгомбо. “Анагаах ухааны дөрвөн үндэс” Төвд Монгол хадмал, доод тал, Үндэстний хэвлэлийн хороо, Бээжин: 1991, х.516-527
6. Лодойжалба. “Дээдсийн чухал сургааль”, доод тал, ӨМШУТМХХ, 2015, х.600-666
7. *ᠮᠢ ᠷᠢᠭ᠎ᠠ ᠳᠡᠭᠡᠰᠢᠭᠡᠯᠡᠨᠨᠦᠳᠡᠨ ᠴᠢᠮᠡᠭ* mi rigs dpe skrun khan, 2005, х.677-725
8. Дэсридсанжайжамц. “Хөх биндэрьяа” дээд тал, ӨМШУТМХХ, 2015, х.267-285
9. *ᠴᠢᠭᠠᠭᠠᠨ ᠪᠣᠯᠣᠷ ᠲᠣᠯᠢ* mi rigs dpe skrun khan, 2005, х.323-446
10. Дарма маарамба Лувсанчойдиг. “Алтан хадмал”, доод тал, ӨМШУТМХХ, 2015, х.660-736

11. *ᠮᠢ ᠷᠢᠭ᠎ᠠ ᠳᠡᠭᠡᠰᠢᠭᠡᠯᠡᠨᠨᠦᠳᠡᠨ ᠴᠢᠮᠡᠭ* mi rigs dpe skrun khan, 2005, х.554-870
12. Данзанпунцог. “Эмийн хир үгүй болор эрхи”, дээд тал, ӨМШУТМХХ, 2015, х.1-160
13. *ᠮᠢ ᠷᠢᠭ᠎ᠠ ᠳᠡᠭᠡᠰᠢᠭᠡᠯᠡᠨᠨᠦᠳᠡᠨ ᠴᠢᠮᠡᠭ* mi rigs dpe skrun khan, 2005, х.47-154
14. Ишбалжир. “Цагаан болор толь”, ӨМАХХ, 2012, х.224-240
15. Ишбалжир. “Цагаан болор толь”, ӨМШУТМХХ, 2015, х.19-200
16. Жамбалдорж. “Монгол эмийг зөв таних толь”, ӨМШУТМХХ, 2015, х.30-95
17. Жамбалдорж. “Монгол эмийг зөв таних толь”, тал 2, ӨМАХХ, 1988 он, х.25-56
18. Хайдав Ц., Шерхан О. “Монгол ардын эмнэлэгт хэрэглэгдэж байсан зарим эрдэс”, УБ, 1975, х.3-86
19. Ганбаатар Т., Даваадорж Б., Оюунчимэг Н. “Монголчуудын уламжлалт эмнэлэгт хэрэглэгдэж байсан зарим эрдсүүд”, УБ, 1993, х.5-23
20. Анхцацрал Л. Эрдсийн гаралтай зарим эмийн түүхий эдийн илт өгүүлэх нэрийн тухай, “Монголын эм зүй, эм судлал”, 2014, No1, х.5-7
21. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх, УБ, 2006, х.26-32
22. Дашзэвэг Н. Монголын уламжлалт анагаах ухааны товч түүх, УБ, 1988, х.6-13
23. Жигмэд Б. Монгол анагаах ухааны түүх болон сурвалж бичиг. Ляонингын үндэстний хэвлэлийн хороо, 2004, х.265
24. Дашням Б. “Эрдэс судлал”, Дархан, 2001, х.5-180
25. Алтанчулуу Д., Амарсайхан Д., Содгэрэл Т., Сээсрэгдорж С. Тойн Жамбалдоржийн намтрыг хөөж тодруулсан нь, “Дорно дахины уламжлалт анагаах ухаан”, 2015, No9, х.51-55

Товчилсон үгийн жагсаалт:

ӨМӨЗО- Өвөр Монголын Өөртөө Засах Орон
 АУДҮ-Анагаах ухааны дөрвөн үндэс
 ӨМШУТМХХ-Өвөр Монголын Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Хяналтын Хороо

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
 Академич Ш.Болд*